



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 5/08

Бэрх хот

**Г.Түмэнбаярыг үүрэгт
ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Төрийн албаны тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалт, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9 дэх заалт, 83 дугаар зүйлийн 83.1, 83.2, 83.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэрх хотын Соёлын ордны захирал Гэндэндоржийн Түмэнбаярын эрүүл мэндийн шалтгааны улмаас гаргасан ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Г.Түмэнбаярын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Г.Осгонжаргал (Соёлын ордны нягтлан бодогч)

Нарийн бичиг: Д.Болор-Эрдэнэ (Соёлын ордны архив, бичиг хэргийн ажилтан)

Гишүүд: Б.Наранжаргал (Соёлын ордны нярав)

Ж.Гэрэлтуяа (ЗАА-ны нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Ичинхорлоо (ЗАА-ны нярав)

2. Г.Түмэнбаяртай цалингийн болон ээлжийн амралтын холбогдох тооцоог хийж дуусгахыг Соёлын ордны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН

